



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй барилга байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 205 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/42 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өргөтгөлийн барилга шинээр барих болсонтой холбогдуулан Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй нийт 276,754,590 (хоёр зуун далан зургаан сая долоон зуун тавин дөрвөн мянга таван зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг актлан, данс бүртгэлээсээ хасч өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв (Ц.Лхагва)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилгыг буулгахад гарах хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглаж болох материалыг худалдан борлуулж 11,575,000 (арван нэгэн сая таван зуун далан таван мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА ~~М.БАЯРАА~~

11505000010

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2022 оны 01 дугаар сарын
27-ний өдрийн 1923 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

| № | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Байршил | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл /2021.12.07/ | Үлдэгдэл үнэ | Тайлбар |
|-----------------------------------|---------------------|---------------------|--|-------------|---------------------------------|--------------|---|
| 1 | Өргөтгөлийн барилга | 1985 | ЧД-ийн 4 дүгээр хороо, Сүхбаатарын гудамж, СУИС-ын замын урд | 276,754,590 | 24,733,909 | 252,020,681 | Шинээр эмнэлгийн өргөтгөлийн барилга барих болсон |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | 276,754,590 | 24,733,909 | 252,020,681 | |